



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/190

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 16 дугаар зүйлийн 16.2.5, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын “Номадс Фүүд” ХХКомпаний “Дэлгэрхангай плаза”-д архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. “Цоглог ертөнц” ХХКомпаний “Цоглог” хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах “Мандалговь-Импекс” ХХКомпаний архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасугай.

Гурав. Сайнцагаан сумын “Номадс Фүүд” ХХКомпаний “Дэлгэрхангай плаза”, “Цоглог ертөнц” ХХКомпаний “Цоглог” хүнсний дэлгүүр, “Мандалговь-Импекс” ХХКомпаний зоогийн газар ажиллах цагийн хуваарийг 08.00-24.00 “Цагаан зоо” ХХК-ны Тоодог хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 08.00-23.00 хүртэл хугацаагаар баталсугай.

Дөрөв. Адаацаг сумын “Эрдэнэ-Ухаа” ХХК-ны жуулчны баазуудын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасугай.

Тав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэлтэс /Б.Очирдорж/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200574